ЛОГИСТИКИЙН СҮЛЖЭЭНИЙ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Мэдээлэл лавлагаа)

Г.Билгээ, Ч.Онончимэг

АГУУЛГА

Оршил

Логистикийг ерөнхий байдлаар зохицуулсан эрх зүйн актуудын лавлагаа
1. Монгол Улсын хууль
2. УИХ-ын тогтоол, бодлогын баримт бичиг
3. Олон улсын гэрээ, конвенц
4. Засгийн газрын тогтоол

ОРШИЛ

Судалгааны зорилго

Монгол Улсын хууль тогтоомжид тээвэр, нефть, хийн хоолой, холбооны болон цахилгааны дулаан дамжуулах шугам, бараа бүтээгдэхүүний агуулах, тээврийн нэгдсэн логистикийн сүлжээний асуудлыг хэрхэн зохицуулсан талаар мэдээлэл бэлтгэхэд оршино. Энэхүү ерөнхий зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд дээр дурдсан салбаруудын логистикийн сүлжээг Олон Улсын гэрээ, конвенци, Монгол Улсын хууль тогтоомжийн гол заалт, зохицуулалтыг эрх зүйн мэдээллийн нэгдсэн www.legalinfo.mn сайтаас хайлт хийсэн болно.

Судалгаанд дараах баримт бичгүүдийг хамруулсан болно.

№	*Баримт бичиг*	*Хайлтын тоо хэмжээ*	*Хайлтын үр дүн*
1	Логистикийн асуудлаар Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенц	138	5
2	Монгол Улсын хууль	543	24
3	Бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүд	1314	28

Судалгааны үр дүн

Манай улсын хувьд логистикийн тухай ойлголт нь дан ганц үйлчилгээний салбарын тээвэр гэсэн ойлголтоор төсөөлөн үзэж, асуудал нь хөрөнгө мөнгөний асуудлаас шалтгаалдаг гэсэн хандлага нийтлэг юм. Гэвч логистикийн тухай ойлголт нь нийгмийн бүхий л салбарыг хамарсан, маш өргөн цар хүрээтэй, эдийн засгийн бүхий л оролцогчдод хүрч үйлчилдэг салбар юм.

Өмнө гүйцэтгэсэн “Логистикийн систем, гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт” сэдэвт судалгаанд логистикийн салбарын талаар ойлголт, манай улсын логистикийн өнөөгийн байдал, чиг хандлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дэлгэрэнгүй байдлаар авч үзсэн бөгөөд энэ удаагийн мэдээлэл лавлагаанд манай орны логистикийн салбарын эрх зүйн зохицуулалтыг маш ерөнхий байдлаар түүвэрлэн товч авч үзсэн болно.

Учир нь манай улсын хувьд логистикийн салбарын хөгжил муу, энэ талаарх ойлголт нь шинэлэг учир эрх зүйн зохицуулалт нь маш хангалтгүй байлаа. Харин 2012.05.22-ны

өдөр батлагдсан Инновацийн тухай хуулийн 21.1.5-д “агуулах, тээвэрлэлт, логистикийн үйлчилгээ үзүүлэх” гэсэн зохицуулалтаас бусдаар логистикийн салбарын зохицуулалт бараг байхгүй гэж үзэж болохоор байлаа.

Мөн манай улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хүрээнд логистикийн салбарын эрх зүйн зохицуулалт дутмаг төдийгүй, аливаа нэг салбарын хувьд бүрэн цогц байдлаар зохицуулсан байдал хангалтгүй, нэгдсэн бодлого байхгүй байна.

Иймд цаашид логистикийн салбарын өндөр ач холбогдол, эдийн засгийн тэргүүн зэргийн үүргийг олон нийт болон эрх барих түвшинд таниулах, сурталчлах, улмаар энэ талаар бодлого, боловсруулан хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын бүтцэд яам, агентлагт нэгжийг бий болгох, мөн түүнчлэн логистиктой холбоотой төрийн бодлогыг тодорхой болгох, эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай байгаа юм.

Логистикийг ерөнхий байдлаар зохицуулсан эрх зүйн актуудын лавлагаа

1. Монгол Улсын хууль

№	*Баримт бичгийн нэр, агуулга*	*Зохицуулж буй салбар*
1	**Автотээврийн тухай хууль /1999.06.04/** 1.1. Энэ хуулийн зорилт нь автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон автотээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, автотээвэрлэлт болон автотээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 3.1.1. “автотээврийн хэрэгсэл” гэж зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүл, цахилгаан тээврийн хэрэгслийг	• Тээврийн логистик • Тээврийн сүлжээ, дамжин өнгөрөх • Цахилгаан, эрчим хүч дамжин өнгөрөх логистик
2	**Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай /2002.06.28/** 4.1. “Алтанбулаг” бүсэд цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж, авто, төмөр зам, телекоммуникацийн үндсэн сүлжээний салбарт хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгийг албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно. 4.2. ”Алтанбулаг” бүсэд агуулахын аж ахуй, ачиж буулгах байгууламж, зочид буудал барьж байгуулахад хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс орлогын албан татвараас 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө. 4.3. “Алтанбулаг” бүсэд бараа, бүтээгдэхүүнийг хадгалах, хамгаалах, сав, баглаа боодлыг сайжруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа, 10 болон түүнээс дээш жил ажиллахаар чөлөөт бүсийн захирагчийн ажлын албатай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс тооцон орлогын албан татвараас эхний жилд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.	• Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүн дамжин өнгөрөх, агуулах, гаалийн талбай • цахилгаан, дулаан дамжуулах шугам **сүлжээ**
3	**Авто замын тухай хууль /**1998.01.02**/** 1.1. Энэ хуулийн зорилт нь авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах, хамгаалах, ашиглах, санхүүжүүлэх, хянах болон төр, зам ашиглагч байгууллага, иргэний хооронд энэ талаар үүсэх харилцааг зохицуулахад оршино. 5.1. Төрийн захиргааны төв байгууллага дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.1.3. авто замын сүлжээн дэх олон улсын болон улсын чанартай замын жагсаалт /замын чиглэл, урт/-ыг батлах; 6.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга авто замын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.1. авто замын сүлжээг хөгжүүлэх төрийн бодлоготой уялдуулан тухайн орон нутгийн авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчилж хамгаалах бодлого боловсруулж төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх, хэрэгжилтийг зохион байгуулах; 10.1. Авто замын сүлжээ нь олон улсын, улсын, орон нутгийн чанартай авто замуудаас бүрдэнэ.	• Тээврийн нэгдсэн логистик • Бараа бүтээгдэхүүн худалдааны логистик

<table>
<tr><td>4</td><td>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /2006.06.29/
12.1.Дараах зардлыг албан татвар ногдох орлогоос хасч тооцсоны үндсэн дээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно:
12.1.33.үйлдвэрлэл, технологийн паркийн эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж, бохир усны шугам, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, харилцаа холбооны дэд бүтэц бий болгоход оруулсан хөрөнгө.</td><td>• цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ</td></tr>
<tr><td>5</td><td>Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль /2003.05.30/
1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын агаарын зайг нисэхэд ашиглах, Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдалд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.лсын агаарын зайг нисэхэд ашиглах, Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдалд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
3.1. Энэ хууль нь Монгол Улсын агаарын зайг иргэний болон улсын нисэхэд ашиглахад үйлчилнэ.</td><td>• Агаарын тээврийн логистик</td></tr>
<tr><td>6</td><td>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012.05.17/
<table><tr><td rowspan="2">Төслийн ангилал</td><td colspan="2">Хариуцан гүйцэтгэгч</td></tr><tr><td>Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</td><td>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар</td></tr><tr><td>5.Дэд бүтцийн хөгжлийн төсөл</td><td>- 1 мвт-аас илүү хүчин чадал бүхий эрчим хүчний станц
- 35 кв-аас илүү хүчдэл бүхий цахилгаан дамжуулах шугам
- дулааны шугам
- усан цахилгаан станц
- төмөр зам
- нисэх буудал
- улс, хот хоорондын зам
- улс хот хоорондын холбоо
- нефтийн бүтээгдэхүүний агуулах</td><td>- 1 мвт хүртэл хүчин чадал бүхий эрчим хүчний станц
- 35 кв хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам
- тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд дамжуулах дулааны шугам
- орон нутгийн чанартай зам, холбоо -шатахуун түгээх станц</td></tr></table></td><td>• Дулаан, эрчим хүчний шугам сүлжээ</td></tr>
<tr><td>7</td><td>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль /2012.05.17/
6.1.4.эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны орчин.</td><td>• Тээврийн сүлжээ, дамжин өнгөрөх
• Цахилгаан, эрчим хүчи дамжин өнгөрөх логистик</td></tr>
</table>

8	**Гаалийн тухай хууль /2008.05.20/** 1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэдээс гомдол гаргах, түүнийг нь гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 3.1.13.“гаалийн бүрдүүлэлтийн горим” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн талаар тогтоосон хэм хэмжээ, нөхцөл, шаардлагыг; 3.1.18.“гаалийн хяналтын бүс” гэж бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналт дор ачих, буулгах, шилжүүлэн ачих, хадгалах, тээвэрлэх, гаалийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон байр, агуулах, талбайг; 5.1.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхэд шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг холбогдох этгээд гаалийн хууль тогтоомжид заасны дагуу гаалийн байгууллагад гаргаж өгнө. 6.1. Аливаа этгээд энэ хууль болон Монгол Улсын олон улсын гэрээ /цаашид “олон улсын гэрээ” гэх/-нд заасан нөхцөл, журмын дагуу бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр чөлөөтэй нэвтрүүлэх эрхтэй. 6.2. Хуульд зааснаас бусад тохиолдолд бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр орсон үеэс мэдүүлэгчид олгох хүртэл, эсхүл бараа, тээврийн хэрэгслийг мэдүүлсэн үеэс улсын хилээр гарах хүртэлх хугацаанд тэдгээрийг ашиглах, эзэмших, захиран зарцуулахыг хориглоно. **39 дүгээр зүйл. Барааг түр хадгалах** 39.1.Барааг гаалийн хяналтад авсан үеэс гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах хүртэлх хугацаанд гаалийн тарифын болон тарифын бус хязгаарлалтгүйгээр түр агуулахад хадгална. 39.2.Мэдүүлэгч энэ хуулийн 44.1, 44.2-т заасан хугацаанд бараатай холбогдсон мэдээллийг гаалийн байгууллагаас авч болно. **40 дүгээр зүйл.Түр агуулах** 40.1.Түр агуулах нь битүү агуулах байр, эсхүл задгай талбай байж болно. **44 дүгээр зүйл. Хадгалалтын хугацаа** 44.1.Барааг түр агуулахад 2 сар хүртэл хугацаанд хадгалах ба гаалийн байгууллага энэ хугацааг 1 сар хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно. 44.2.Түргэн гэмтэх, эсхүл аюултай барааг 7 хоног хүртэл хугацаагаар хадгалах ба гаалийн байгууллага энэ хугацааг 7 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно. 44.3.Барааг түр агуулахад оруулсан, эсхүл шилжүүлсэн гэж тооцсон өдрөөс эхлэн түр хадгалах хугацааг тоолно. 44.4.Энэ хуулийн 42.3-т заасан барааг мөн хуулийн 44.1, 44.2-т заасан хугацаа хамаарахгүй. **45 дугаар зүйл. Түр агуулахад хадгалах барааг хийгдэх ажиллагаа** 45.1.Түр агуулахад хадгалагдаж байгаа барааг болон түүний сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр гаалийн байгууллагын зөвшөөрлөөр арчилгаа, үйлчилгээ хийж болно. 45.2.Мэдүүлэгч нь гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гаалийн бүрдүүлэлт хийхээс өмнө барааг үзэж сорьц, дээж, загвар авч болно.**48 дугаар зүйл. Түр агуулахад тавигдах шаардлага** 48.1.Түр агуулах нь бараа хадгалах дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна: 48.1.2.бараа ачих, буулгах, шилжүүлэн ачих тоног төхөөрөмж, гаалийн хяналтын техник хэрэгсэл, тавцан, зам, талбай, цахилгаан, ус суваг, холбооны шугам сүлжээтэй байх;	• Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүн дамжин өнгөрөх, агуулах, гаалийн талбай • Тээврийн сүлжээ, дамжин өнгөрөх • Цахилгаан, эрчим хүч дамжин өнгөрөх логистик

9	**Замын-Үүд худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай /2003.06.20/** 5.4."Замын-Үүд" бүсэд дараах чиглэлээр албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлнэ: 5.4.1.эрчим хүчний шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах, цэвэрлэх байгууламж, авто, төмөр зам, харилцаа холбооны үндсэн сүлжээнд аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгийг албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно; 5.4.2.бүсэд агуулахын аж ахуй, ачиж буулгах байгууламж, зочид буудал барьж байгуулахад хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс тухайн бүсээс олох орлогын албан татвараас 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө; 5.4.3."Замын-Үүд" бүсэд 10 болон түүнээс дээш жил ажиллахаар чөлөөт бүсийн захирагчийн ажлын албатай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс тооцон орлогын албан татвараас эхний жилд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө. 5.5."Замын-Үүд" бүсэд дараах чиглэлээр газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ: 5.5.1.худалдаа, нийтийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс эхний 3 жилд газрын төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө; 5.5.2.энэ хуулийн 5.4.1-д заасан бүсийн дэд бүтцийг бүрдүүлэх ажил эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс эхний 5 жилд газрын төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 30 хувиар хөнгөлнө.	• Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүн дамжин өнгөрөх, агуулах, гаалийн талбай • Тээврийн сүлжээ, дамжин өнгөрөх • эрчим хүчний шугам **сүлжээ**
10	**Инновацийн тухай /2012.05.22/** 21.1.Паркийн нутаг дэвсгэрт дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулна: 21.1.1.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил явуулах, дэвшилтэт техник, технологийг дамжуулах; 21.1.2.инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл; 21.1.3.сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн сүлжээ бий болгох; 21.1.4.нийгмийн суурь үйлчилгээ, хот төлөвлөлт, газар зохион байгуулалтыг тухайн бүс, орон нутгийн чадавхид түшиглэн цогцолборoор байгуулах; 21.1.5.агуулах, тээвэрлэлт, логистикийн үйлчилгээ үзүүлэх; 21.1.6.паркийн нутаг дэвсгэрт хэвийн үйл ажиллагаа явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.	• Нэгдсэн логистикийн үйлчилгээ үзүүлэх • сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн **сүлжээ** бий болгох;
11	**Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээг соёрхон батлах тухай хууль** /2010.10.21/ Энэхүү Гэрээнд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 12. "Хил дамнасан байгууламж" гэж хилийн шугамыг дайран гарсан төмөр зам, авто зам, газрын тос, хий дамжуулах хоолой, цахилгаан, холбооны шугам, гүүр, усны далан, усны хашлага зэрэг байгууламжийг хэлнэ.	• Тээврийн логистик • Цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж
12	**Өрсөлдөөний тухай хууль /2010.06.10/** 7.1.3.аж ахуй эрхлэгчээс борлуулалтын нэмэлт нөхцөлийг шаардах, зах зээлд ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах. Энэ нь бүс нутгийн байршлаас хамаарсан тээврийн бодит зардлыг тооцсон бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс бөөний болон жижиглэнгийн худалдан авагчид өгч байгаа урамшуулалд хамаарахгүй;	• Тээврийн логистик
13	**Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль** /2007.01.11/ 1.1. Энэ хуулийн зорилт нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглаж эрчим хүч үйлдвэрлэх, нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 10.1. Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах тухай үйлдвэрлэгч, дамжуулагчийн хоорондын гэрээг эрчим хүчний зохицуулах газраас баталсан загварын дагуу байгуулна. 10.2. Энэ хуулийн 10.1-д заасан гэрээнд үйлдвэрлэн нийлүүлэх цахилгааны чадал, чанарын үзүүлэлт, хэмжээ, тариф, хугацаа, цахилгааны тоолуур, хэмжих хэрэгслийн байршил, түүний төрөл, загвар, нарийвчлал, итгэлцүүрийн хэмжээ, дугаар, цахилгааны төлбөр, тооцооны нөхцөл, гэрээг цуцлах үндэслэл, талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тусгана.	• Мэдээлэл, технологийн сүлжээ, дамжин өнгөрөх • Цахилгаан, эрчим хүч дамжин өнгөрөх логистик

14	**Төмөр замын тээврийн тухай хууль /2007.07.05/** 3.1.23."төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа" гэж ачаа, тээш, ачаан тээш, чингэлгийг тээвэрлэхэд бэлтгэх, хүлээн авах, ачих, тээвэрлэх, буулгах, хүлээлгэн өгөх болон зорчигч тээвэрлэх, сэлгээний ажил гүйцэтгэх үеийн зохион байгуулалт, технологийн харилцан уялдаатай цогцолбор ажил, үйлчилгээг; 21.1.Нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч нь суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч болон дайвар үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулж өөрийн зам, талбайд ачаа, ачаан тээш, вагон, чингэлгийг тээвэрлэлтэд бэлтгэх, ачих, буулгах, хадгалах үйлчилгээ үзүүлнэ.	• Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүний агуулах
15	**Усан замын тээврийн тухай хууль /2003.11.28/** 1.1.Энэхүү хуулийн зорилт нь усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, усан замын тээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 3.1.8."тээвэрлэлт" гэж усан замын тээврийн хэрэгслээр зорчигч болон ачааг усан замын нэг зогсоолоос нөгөө зогсоолд шилжүүлэн зөөхтэй холбогдсон ажил, үйлчилгээг; 3.1.9."тээвэрлэгч" гэж усан замын тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг; 3.1.10."тээвэрлүүлэгч" гэж усан замын тээвэрлэлтийн үйлчилгээ хэрэглэгчийг; **11 дүгээр зүйл. Тээвэрлэлт гүйцэтгэх** 11.1.Усан замын тээвэрлэлтийг Иргэний хууль болон энэ хуульд нийцсэн гэрээний дагуу гүйцэтгэнэ. 11.2.Усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	• Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүний агуулах
16	**Улсын нисэхийн тухай хууль** /2003.05.30/ 1.1. Энэ хуулийн зорилт нь улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 10.1. Улсын агаарын хөлгийн нислэг дараах ангилалтай байна: 10.1.1. байлдааны үүргийн нислэг; 10.1.2. онцгой үүргийн нислэг; 10.1.3. тусгай үүргийн нислэг; 10.1.4. арилжааны нислэг. 10.3.2. тогтоосон агаарын замаас гадна зайлшгүй шаардлагатай үйлдэх улсын агаарын хөлгийн нислэг. 10.5. Улсын агаарын хөлгөөр арилжааны нислэг үйлдэх бол Иргэний нисэхийн тухай хуулийг баримтална.	• Агаарын тээврийн логистик
17	**Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхийн эдийн биржийн тухай хууль /2011.06.02/** 1.1.Энэ хуулийн зорилт нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино. 5.1.Бирж нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ: 5.1.11.стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох	• Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүний агуулах
18	**Хүнсний тухай хууль /2012.12.20/** 11.2.4.стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх, эсхүл энэ шаардлагыг хангасан хуулийн этгээд, байгууллагатай гэрээтэй байх.	• Бараа бүтээгдэхүүний агуулах

19	**Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай /2012.12.20/** 1.1.Энэ хуулийн зорилт нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино 4.1.6.“хүнсний сүлжээ” гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг;	• Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүний агуулах
20	**Харилцаа холбооны тухай хууль** /2001.10.18/ 11.1.Зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх, шинээр сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх зорилгоор шуудангийн болон цахилгаан холбооны бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг тус тус бүрдүүлж, зарцуулна. 16.1.Харилцаа холбооны сүлжээ нь цахилгаан холбоо, шуудан, радио, телевизийн болон мэдээллийн /интернет, компьютер зэрэг бусад/ сүлжээнээс бүрдэнэ.	• Мэдээлэл, технологийн сүлжээ, дамжин өнгөрөх • Цахилгаан, эрчим хүч дамжин өнгөрөх логистик
21	**Хот байгуулалтын тухай хууль** /2008.05.29/ 14.3.Инженерийн шугам сүлжээний болон зам тээврийн бүсэд төмөр зам, усан болон авто тээвэр, агаарын тээвэр, инженерийн /цэвэр, бохир усны, дулаан, холбоо, цахилгааны гэх мэт/ шугам сүлжээний барилга байгууламжийг төлөвлөнө. 21.1.Хот байгуулалтын үйл ажиллагааг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ: 21.1.1.хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүс нутгийн хөгжлийн төслийг хэрэгжүүлэхдээ эхний ээлжинд зам тээвэр, эрчим хүч, холбоожуулалтын үндсэн сүлжээг барьж байгуулах ажлыг хэрэгжүүлж зохицуулах;	• Мэдээлэл, технологийн сүлжээ, дамжин өнгөрөх • Цахилгаан, эрчим хүчи дамжин өнгөрөх логистик
22	**Чөлөөт бүсийн тухай хууль /2002.06.28/** 1.1.Энэ хуулийн зорилт нь чөлөөт бүс байгуулах, түүний хэлбэр, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гаалийн дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. **3 дугаар зүйл. Чөлөөт бүс, түүний хэлбэр** 3.1.”Чөлөөт бүс” гэж гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох, хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ. 3.2.Чөлөөт бүс нь худалдааны, үйлдвэрлэлийн, хөдөө аж ахуйн, аялал жуулчлал-үйлчилгээний, эдийн засгийн гэсэн хэлбэртэй байна. 3.3.Худалдааны чөлөөт бүсэд бараа, бүтээгдэхүүний мөн чанарыг нь алдагдуулахгүйгээр хадгалах, хамгаалах, түүний сав баглаа, боодлыг сайжруулах, борлогдох чанарыг дээшлүүлэх, борлуулах үйл ажиллагаа эрхэлнэ. 3.4. Үйлдвэрлэлийн чөлөөт бүсэд тэргүүний, дэвшилтэт технологи бүхий, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж борлуулах үйл ажиллагаа эрхэлнэ. 3.5. Хөдөө аж ахуйн чөлөөт бүсэд газар тариалан, мал аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаа эрхэлнэ. 3.6.Аялал жуулчлал-үйлчилгээний чөлөөт бүсэд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн зохистой дэд бүтэц бүхий үйлчилгээний цогцолбор бүрдүүлж, бүх төрлийн үйлчилгээ эрхэлнэ. 3.7. Эдийн засгийн чөлөөт бүсэд энэ хуулийн 3.3-3.6-д заасан үйл ажиллагааг хосолсон буюу нэгтгэсэн байдлаар эрхэлнэ.	• Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүний агуулах

23	**Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай /2003.12.18/** 4.1.”Цагааннуур” бүсэд цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж, авто, төмөр зам, телекоммуникацийн үндсэн сүлжээний салбарт хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгийг албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно. 4.2.”Цагааннуур” бүсэд агуулахын аж ахуй, ачиж буулгах байгууламж, зочид буудал барьж байгуулахад хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс орлогын албан татвараас 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө. 4.3.”Цагааннуур” бүсэд бараа, бүтээгдэхүүнийг хадгалах, хамгаалах, сав, баглаа боодлыг сайжруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа 10 болон түүнээс дээш жил ажиллахаар чөлөөт бүсийн захирагчийн ажлын албатай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс тооцон орлогын албан татвараас эхний жилд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.	• Тээврийн логистик • Бараа бүтээгдэхүүний агуулах • цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж
24	**Эрчим хүчний тухай хууль** /2001.02.01/ 1.1. Энэ хуулийн зорилт нь эрчим хүчний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүчний барилга байгууламж барих болон эрчим хүчийг хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино. 3.1.5.”нэгдсэн сүлжээ” гэж хоёр буюу түүнээс дээш аймгийн төвийг хамран цахилгаан хангамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хоорондоо холбогдсон эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээг; 3.1.7.“цахилгаан дамжуулах сүлжээ” гэж цахилгаан дамжуулах зориулалт бүхий 110 кв, түүнээс дээш хүчдлийн шугам, дэд станц, түүнчлэн энэ сүлжээнд холбогдсон, эсхүл техник, технологийн хувьд энэ сүлжээнд хамрагдах шаардлагатай бусад хүчдлийн шугам, дэд станцыг; 3.1.8.“цахилгаан түгээх сүлжээ” гэж эх үүсвэрээс шууд холбогдсон болон цахилгаан дамжуулах сүлжээний дэд станцаас хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэлх шугам, дэд станцыг;	• Цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж

2. УИХ-ын тогтоол, бодлогын баримт бичиг

№	*Баримт бичгийн нэр, агуулга*	*Зохицуулж буй салбар*
1	УИХ-ын 2010.06.24 №32 тогтоол “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” 1/ Монгол Улсын экспортын ачааны тээвэрлэлтийг ОХУ болон БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхэд тухайн улсын төмөр замын байгууллагаас ижил төрлийн ачааны тээвэрлэлтэд үзүүлж байгаа тээврийн болон вагон ашиглалтын хамгийн доод хөлс, ачаа хүргэх хугацаа, бусад төлбөр, хураамжтай дүйцэх буюу илүү хөнгөлөлттэй нөхцөлийг урт хугацаанд мөрдөхөөр тохиролцож, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан тухайн чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах арга хэмжээ авах	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
2	УИХ-ын 2008.01.31 №12 тогтоол “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” батлах тухай	• Тээврийн логистик • эрчим хүчний шугам **сүлжээ**
3	УИХ-ын 2003.06.12 № 24 тогтоол Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги батлах тухай	• Тээврийн логистик дамжин өнгөрөх • Бараа бүтээгдэхүүн агуулах, • эрчим хүчний шугам **сүлжээ**

4	УИХ-ын 2005.04.21 № 25 тогтоол Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтыг батлах тухай	• Тээврийн логистик дамжин өнгөрөх • Бараа бүтээгдэхүүн агуулах, эрчим хүчний шугам **сүлжээ**
5	УИХ-ын 1996.05.03 №26 Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай	• Тээврийн логистик дамжин өнгөрөх • Бараа бүтээгдэхүүн агуулах,
6	УИХ-ын 2010.06.24 №34 тогтоол Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай	• Тээврийн логистик дамжин өнгөрөх • Бараа бүтээгдэхүүн агуулах,
7	УИХ-ын 2010.06.24. №32 тогтоол Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай	• Тээврийн логистик дамжин өнгөрөх • Бараа бүтээгдэхүүн агуулах,
8	УИХ-ын 2005.06.09 №32 Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр батлах тухай	• эрчим хүчний шугам **сүлжээ**

3. Олон улсын гэрээ, конвенц

№	*Баримт бичгийн нэр, агуулга*	*Зохицуулж буй салбар*
1	**Далайд гарцгүй улсын дамжин өнгөрөх худалдааны тухай конвенц** 1965 оны 7 дугаар сарын 8-ны өдөр баталж, 1967 оны 6 дугаар сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон Дамжин өнгөрч буй бараанд гаалийн хураамж ногдуулахгүй Дамжин өнгөрөгч тээврийн хэрэгсэлд дамжин өнгөрүүлэгч улсын тээврийн хэрэгсэлд ногдуулдагаас илүү татвар буюу хураамжийг ногдуулахгүй. iii) бусад тээврийн хэрэгсэл, түүнчлэн хэлэлцэн тохирогч холбогдох улсууд харилцан тохиролцсоны үндсэн дээр дамжуулагч хоолой болон байгалийн хий дамжуулах шугам зэргийг дамжин өнгөрөх хөдөлгөөнд энэ зүйлийн агуулгад нийцүүлэн ашиглаж буй тохиолдолд тус тус багтаана. 1. Энэхүү конвенцийн заалтын дагуу дамжин өнгөрөх хөдөлгөөн болон тээврийн хэрэгсэлд дамжин өнгөрөх эрх чөлөөг олгоно. Энэхүү конвенцийн бусад заалтын дагуу хэлэлцэн тохирогч улсууд өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийн хөдөлгөөнийг зохицуулах болон хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээ нь хэлэлцэн тохирогч тухайн улсуудын харилцан хүлээн зөвшөөрсөн, одоогоор ашиглагдаж буй замын чиглэлийн дагуу дамжин өнгөрөх тээвэр хийхэд тус дөхөм үзүүлэхэд чиглэгдэнэ. 2. Дамжин өнгөрөх хөдөлгөөнийг шаардлагагүйгээр саатуулахгүйн тулд хэлэлцэн тохирогч улсууд бололцоотой бол оруулах, гаргах цэгүүд болон шаардлагатай гэж үзвэл шилжүүлэн ачих цэгүүдэд, зохих тээврийн хэрэгсэл болон ачиж буулгах тоног төхөөрөмжөөр хангах үүрэг хүлээнэ.	• Тээврийн логистик дамжин өнгөрөх • Бараа бүтээгдэхүүн агуулах,
2	**Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай марракешийн хэлэлцээр** 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон Экспортын өрсөлдөөний талаархи үүрэг амлалт Гишүүн бүр энэхүү хэлэлцээр болон тухайн гишүүний буултын жагсаалтад заасан үүрэг амлалттай тохирч байгаагаас өөр тохиолдолд экспортын татаас олгох үүрэг хүлээхгүй (е) экспортын бараа нийлүүлэхэд зориулан экспортын бус ачааны тээврийнхтэй харьцуулахад илүү таатай нөхцөлөөр засгийн газраас тогтоосон буюу эрх олгосон дотоодын тээврийн тариф	• Тээврийн логистик дамжин өнгөрөх • Бараа бүтээгдэхүүн агуулах, • Худалдааны логистик

3	**Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээ** 2010 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Хил нэвтрэх Талууд зорчигч, ачаа тээш, бараа, тээврийн хэрэгслийг тогтоосон боомтоор хил нэвтрүүлнэ.	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
4	**Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай нэгдсэн үндэстний байгууллагын конвенц** 1980 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр баталж, 1988 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон (1) Хэрэв худалдагч гэрээ буюу энэхүү конвенцийн дагуу барааг тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн бөгөөд хэрэв дээр нь тэмдэглэл хийх, тээврийн баримт бичигт заах буюу бусад аргаар барааг гэрээний зорилгод нарийвчлан тодорхойлоогүй бол худалдагч барааг ачуулсан тухай мэдэгдэлд тухайн барааг тодорхойлон худалдан авагчид өгөх ёстой. (2) Хэрэв худалдагч барааг тээвэрлүүлэх үүрэг хүлээсэн бол барааг хүлээн авах газар хүртэл тухайн нөхцөл байдалд тохирсон тээврийн хэрэгслээр болон ийм тээвэрлэлтэд хэрэглэдэг ердийн нөхцөлөөр тээвэрлэхэд шаардлагатай гэрээг байгуулах ёстой (2) Гэсэн хэдий ч дээр нь тэмдэглэл хийх, тээврийн баримт бичигт заах, худалдагчид мэдэгдэл өгөх буюу бусад аргаар барааг гэрээний зорилгод нарийвчлан тодорхойлох хүртэл эрсдэл худалдан авагчид шилжихгүй.	• Тээврийн логистик дамжин өнгөрөх • Бараа бүтээгдэхүүн агуулах,
5	**Аж уйлдвэрийн өмчийг хамгаалах тухай парисын конвенц** 1970 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр буюу 1970 оны 5 дугаар сарын 19-ний өдөр хүчин төгөлдөр болсон /Монгол Улс 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталсан/ Тэмдэг, аж ахуйн нэгжийн нэр: Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашигласан барааг импортлоход хураах (4) Эрх бүхий байгууллагууд бараа дамжин өнгөрөх тохиолдолд хураах үүрэг хүлээхгүй.	• Тээврийн логистик дамжин өнгөрөх

4. Засгийн газрын тогтоол

№	*Баримт бичгийн нэр, агуулга*	*Зохицуулж буй салбар*
1	“Шинэ төмөр зам төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2013.01.26 №28	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
2	Монгол-Хятадын авто тээврийн хэлэлцээр батлах тухай 2011.08.24 №259	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
3	Беларус улстай Олон Улсын автотээврийн харилцааны тухай 2004.04.23 №93	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
4	БНАСАУ-тай худалдааны далайн тээврийн салбарт хамтран ажиллах тухай 2007.08.08 №195	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
5	Украйн улстай Олон Улсын автотээврийн харилцааны тухай төмөр замын салбарт хамтын ажиллагааны тухай хэлэлцээр байгуулах тухай 1995.10.11 №180	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
6	Төмөр замын дагуух шилэн кабелийн сүлжээний ашиглалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2004.04.12 №80	• Цахилгаан, сүлжээ
7	Улс хоорондын тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2006.10.25 №257	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
8	Монгол Улс далайд гаргах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2010.07.07 №167	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
9	Мэдээлэл холбооны сүлжээний давхардлыг арилгах тухай 2013.01.12 №6	• Мэдээллийн сүлжээ

10	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2013.03.16 №100	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
11	Тавантолгойн нүүрсний уурхайг түшиглэн гаалийн бүс байгуулах ажлыг зохион байгуулах тухай 2013.06.22 №225	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
12	Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах тухай 2012.12.01 №150	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
13	Далайд гаргах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2013.04.27 №152	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
14	Хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах журам 2003.01.22 №20	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
15	Олон Улсын автозам, замын байгууламж журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай 2011.04.06 №106	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
16	“Улаанбаатарын дулааны 5-р цахилгаан станц”-ыг барих тухай 2012.12.22 №191	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
17	Автозамын тухай /Ухаа худаг нүүрсний орд газраас Гашуунсухайт боомт хүртэлх/ 2010.03.31 №83	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
18	Бичигт-Зүүн хатавчийн боомтыг байнгын ажиллагаатай болгох тухай 1992.12.24 №249	• Тээврийн логистик дамжин өнгөрөх
19	“Ус-15” дулааны станц барих тухай 2013.01.26 №35	• Цахилгаан, сүлжээ
20	“Шинэ төмөр зам” төслийн санхүүжилтийн тухай 2013.03.07 №82	• Тээврийн логистик дамжин өнгөрөх